



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 0/698

Улаанбаатар хот

**“Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар”
Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот
үйлдвэрийн газрынэргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 985,192,051.72 /есөн зуун наян таван сая нэг зуун ерэн хоёр мянга тавин нэгэн төгрөг далан хоёр мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг “Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ /Г.Баттулга/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 985,192,051.72 /есөн зуун наян таван сая нэг зуун ерэн хоёр мянга тавин нэгэн төгрөг далан хоёр мөнгө/ төгрөгийн үнэ бүхий 10 халаалтын зуухнуудын эргэн ашиглагдах боломжтой хэсгүүдийг сэлбэгийн зориулалтаар авч үнэлэн эргэн танилцуулж ажиллах, ашиглагдахгүй хэсгүүдийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг “Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ /Г.Баттулга/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Үүнээс: Худалдах хөрөнгө							
Актлах хөрөнгө				985,192,051.72			
Татан төвлөрүүлэх хөрөнгө							
Худалдсанаас олох орлого							
НӨАУГ-т төвлөрүүлэх /30 %/							